 НОМИН	"НОМИН ЮНИТИ" ББСБ	Дугаар: ДМ/4-6/01	Иш татсан заалт: Ёс зүйн дүрэм
ЁС ЗҮЙН ДҮРЭМ		Хувилбар: 2	



ХУУЛБАР ХУВЬ

ХҮЧИНГҮЙ ХУВЬ



Хувилалт №.

• БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ

Хувилбар	Товч утга	Батлагдсан огноо, тушаалын дугаар	Мөрдөж эхэлсэн огноо
Хувилбар 1	"Номин Юнити ББСБ" ХХК-ийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд удирдлага, нийт ажилтнуудын албаны үйл ажиллагаанд үнэт зүйл, зарчим, заавал баримтлах ёс зүйн хэм хэмжээг тодорхойлох, тогтоон хэвшүүлэх, даган мөрдүүлэх болон тэдгээртэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах	2020.05.01 № 4-6/13	2020.05.01
Хувилбар 2	СЗХ-оос шинэчлэн баталсан "Компанийн засаглалын кодекс"-д нийцүүлэн шинэчлэв.	2024.07.08 №35/24	2024.07.08

ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧГҮҮД

№	Баримт бичгийн дугаар	Нэр
1	"Номин Холдинг" ХХК	Ёс зүйн дүрэм
2	НУТ-1/001	Баримт бичиг боловсруулах журам

ГАРЧИГ

№	Агуулга	Хуудас
1	Нийтлэг үндэслэл	2-2
2	Алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл, баримтлах зарчим	3-4
3	Ёс зүйн хэмжээ	4-6
4	Ашиг сонирхлын зөрчил, авилга, хээл хахуулиас ангид хуулийн хүрээнд ажиллах	7-7
5	Ёс зүйн зөрчлийг мэдээлэх, шийдвэрлэх	7-8

Хуудас 1 / 9


Ашиглахын өмнө хүчинтэй хувилбар мөн эсэхийг шалгана уу

НОМИН ЮНИТИ ББСБ ХХК

2024 оны 04 дугаар
сарын 08-ны өдөр

№: 35/24

Улаанбаатар
хот



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Ёс зүйн дүрэм шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дэх хэсэг, Компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.4.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Номин Юнити ББСБ" ХХК-ийн "Ёс зүйн дүрэм"-ийн шинэчилсэн найруулгыг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Ёс зүйн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2020 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 4-6/13 тоот тушаалын хавсралтаар батлагдсан ёс зүйн дүрмийг хүчин төгөлдөр бусад тооцсугай.
3. Энэхүү дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ө.Оюун-Эрдэнэ/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.ХОСБАЯР


 НОМИН	"НОМИН ЮНИТИ" ББСБ	Дугаар: ДМ/4-6/01	Иш татсан заалт: Ёс зүйн дүрэм
ЁС ЗҮЙН ДҮРЭМ		Хувилбар: 2	

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү Ёс зүйн дүрэм /цаашид "Дүрэм" гэх/-ийн зорилго нь "Номин Юнити Банк бус санхүүгийн байгууллага" ХХК /цаашид "ББСБ" гэх/-ын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд хууль, дүрэм, журмыг дээдлэх, шударга ёсыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн тэгш хандах, нийт ажилтнуудын үйл ажиллагаанд баримтлах үнэт зүйл, зарчим, ёс зүйн хэм хэмжээг тодорхойлох, тогтоон хэвшүүлэх, даган мөрдүүлэх болон тэдгээртэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах болон энэхүү дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлоход орших ба энэ дүрэм нь ББСБ-ын дүрмийн салшгүй хэсэг болно.
- 1.2 Хамрах хүрээ. Энэхүү дүрмийг ББСБ-ын Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл, Удирдлагын багийн гишүүд, Нийт ажилтнууд зэрэг бүхий л оролцогч талууд өдөр тутамынхаа үйл ажиллагаанд мөрдлөг болгоно.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ


- 2.1 Дүрэмд хэрэглэгдэх нэр томьёог дараах байдлаар ойлгоно. Үүнд:
 - 2.1.1 **"Байгууллагын ашиг сонирхол"** гэж байгууллагын эрхэмлэх үнэт зүйл, баримтлах зарчим, стратеги, менежментийн бодлого, тушаал, шийдвэр, байгууллагад мөрдөгдөж байгаа бүхий л дүрэм, журам, заавар, аргачлалд нийцсэн эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;
 - 2.1.2 **"Хувийн ашиг сонирхол"** гэж ажилтан ажил үүргээ гүйцэтгэхдээ өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;
 - 2.1.3 **"Ашиг сонирхлын зөрчил"** гэж байгууллагын хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтны зүгээс өөрт нь эсхүл тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдэд ашигтай буюу илт давуу байдал тогтоох зорилгоор хийсэн байгууллагын эрх ашигт сөргөөр нөлөөлөх үйлдэл, эс үйлдлийг;
 - 2.1.4 **"Хамаарал бүхий этгээд"** гэж тухайн ажилтан, албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр/нөхөр/ болон түүний эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг;
 - 2.1.5 **"Нэгдмэл сонирхолтой этгээд"** гэж байгууллагын харилцагч, төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигч болон зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтантай эд хөрөнгө, садан төрлийн зэрэг хувийн ашиг сонирхлын холбоо бүхий этгээдийг;
 - 2.1.6 **"Давуу байдал"** гэж албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд бий болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;
 - 2.1.7 **"Ялгаварлан гадуурхалт"** гэж дараах үндэслэлүүдээр харилцагч, удирдлага, хамтран ажиллагсад болон бусдыг үндэс, угсаа, хэл, арьс өнгө, нас хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, улс төрийн үзэл бодол, намын харьяалал, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, эцэг/эхийн статус, боловсрол, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлагаар нь ялгаварлан гадуурхахыг;

 НОМИН	"НОМИН ЮНИТИ" ББСБ	Дугаар: ДМ/4-6/01	Иш татсан заалт: Ёс зүйн дүрэм
ЁС ЗҮЙН ДҮРЭМ		Хувилбар: 2	


- 2.1.8 "Нууцад хамаарах мэдээлэл" гэж байгууллага албан ёсоор олон нийтэд зарласнаас бусад санхүү, бизнесийн холбогдолтой аливаа мэдээ, мэдээлэл, дата болон байгууллагын нийт харилцагчид, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, зээлийн хорооны гишүүд, гүйцэтгэх захиралтай холбогдох зээл, эзэмшиж буй хувьцааны мэдээлэл болон "Хувь хүний нууцын тухай хууль", Нууцынн журам"-р зохицуулсан мэдээлэл;

ГУРАВ. АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 3.1 **Алсын хараа.** Байгаль болон Харилцагчид ээлтэй Цаг хугацаа, Үйлдэл, Орон зайг хэмнэж хүн бүрт зориулагдсан санхүүгийн үйлчилгээг бий болгоно.
- 3.2 **Эрхэм зорилго.** Технологиор Орон зай, Цаг хугацааг хэмнэж, Үйлчилгээгээр Үйлдэлийг хялбаршуулан хүн бүрт зориулагдсан санхүүгийн мэргэжлийн үйлчилгээг бид хүргэнэ.
- 3.3 **Эрхэмлэн дээдлэх үнэт зүйлс**
- 3.3.1 Мэргэжлийн хамт олон
 - 3.3.2 Технологид суурилсан
 - 3.3.3 Стандартыг хэрэгжүүлэгч
 - 3.3.4 Тогтвортой засаглал
 - 3.3.5 Төвлөрсөн санхүүгийн үйлчилгээ
- 3.4 **Баримтлах зарчим**
- 3.4.1 Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмуудыг дээдлэх, системийн тогтвортой байдал, хөгжил дэвшилд өөрсдийн хувь нэмрээ оруулах, байгууллагын нэр хүндийг өргөх, хамгаалах болон зээлдэгч, хувьцаа эзэмшигч, харилцагч нарын ашиг сонирхлыг тэргүүнд тавих;
 - 3.4.2 Хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, байгууллагын эрх ашгийг хувийн эрх ашгаас илүүд эрхэмлэн дээдэлж, шударга бус явдалтай эвлэрэхгүй, бусдыг манлайлан ажиллах;
 - 3.4.3 Хууль бус, гэмт хэргийн шинж чанар агуулсан үйл ажиллагаанд оролцохгүй байх;
 - 3.4.4 Ямагт эелдэг, ажил хэрэгч, найрсаг төрхтэй байж, өөрсдийн сэтгэл хөдлөлийг зөв удирдан бусдын сэтгэл зүйд дарамт учруулахгүй байх;
 - 3.4.5 Удирдах, удирдуулах ёсны зарчмыг баримталж удирдлагаас гаргасан дүрэм журамд нийцсэн шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх;
 - 3.4.6 Ажилтнууд өндөр үр бүтээлтэй, идэвх санаачлагатай ажиллах, хамт олны эвсэг, ажил хэрэгч уур амьсгалыг бүрдүүлж, үргэлж мэдлэг чадвараа дээшлүүлэх, багаар хамтран ажиллахын төлөө бие биедээ ажлын зарчимч шаардлага тавьдаг байх;
 - 3.4.7 Ажилтан бүр өөрийн болон бусдын мэдлэг чадварыг хөгжүүлэх;
 - 3.4.8 Өөрийн хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх;
 - 3.4.9 Удирдлага, хамт ажиллагсад, харилцагч нарыг ялгаварлан гадуурхахгүй, хүндэтгэн харьцах;


 НОМИН	"НОМИН ЮНИТИ" ББСБ	Дугаар: ДМ/4-6/01	Иш татсан заалт: Ёс зүйн дүрэм
ЁС ЗҮЙН ДҮРЭМ		Хувилбар: 2	

- 3.4.10 Хувийн зохион байгуулалт сайтай, ажил хэрэгч хувцаслаж, цэвэрч нямбай байх ба ББСБ-ын үйлчилгээний стандартыг баримталж ажиллана;
- 3.4.11 Албан тушаал, эрх мэдлийн болон эдийн шуналгүй, төлөв даруу байж, бардам зан, атаархал, өшөө хорслоос хол хөндий байх;
- 3.4.12 Эрүүл ухаалаг амьдралын зарчим, хэв шинжийг мөрдөж согтууруулах ундаа болон мөрийтэй тоглоом, зугаа цэнгэлд донтохгүй байх;
- 3.4.13 Мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хадгалах, найдвартай байдлыг хангаж ажиллах;
- 3.4.14 Ажил үүргээ гүйцэтгэж байгаа үед худалдаа арилжааны шинж чанартай санал тавих, байгууллагын мэдээллийн сувгаар хувийн шинжтэй зар, үнэн бодит эсэх нь тодорхойгүй мэдээлэл тараах, ажлын байран дээр худалдаа хийх ялангуяа архи согтууруулах ундаа болон тамхины төрлийн бараа бүтээгдэхүүн зарах зэрэг бусдын ажилд садаа болохуйц үйл ажиллагаа явуулахгүй байх;
- 3.4.15 Байгууллагын өмч, эд хөрөнгө, техник хэрэгсэл, албаны мэдээллийг албан бус зорилгоор ашиглахгүй байх;
- 3.4.16 Гаргасан алдаа дутагдлыг нуун дарагдуулах, хуурамч, төөрөгдүүлсэн мэдээлэл аливаа хэлбэрээр түгээх, алдаа дутагдлаас үүссэн эсвэл үүсэж болзошгүй байгууллагын нэр хүнд, үйл ажиллагаанд гэм хортой, үл нөлөөтэй мэдээллийг хариуцсан албан тушаалтанд үл мэдэгдэх, нуун дарагдуулахыг цээрлэнэ;
- 3.4.17 Энэ дүрмийн 3.4.13-т заасны дагуу байгууллагын дотоод мэдээлэл болон бизнесийн нууцад хамаарах аливаа мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох хүртэл чандлан нууцлах ба хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглахыг хориглоно;
- 3.4.18 Өөрийн шууд удирдлагад ажиллаж буй ажилчдын ажлын гүйцэтгэлийг шударга бусаар үнэлэхгүй, хувийн сонирхлоор асуудалд хандахгүй байх;
- 3.4.19 Ажлын байранд ажилтны хэм хэмжээг баримталж бие авч явах байдал, хувцаслалт зэрэгт анхаарах;
- 3.4.20 Ажлын байранд архи, согтууруулах ундааны төрлийн зүйл хэрэглэхгүй, хэрэглэсэн үедээ ажлын байранд ирэхгүй байх. /Уг хэм хэмжээнд ажлын байрнаас гадуур ажил үүрэг гүйцэтгэх болон албан томилолтоор явах тохиолдол мөн хамаарна/
- 3.4.21 Бусдын эрх чөлөө, нэр хүндэд нь халдахгүй байх;
- 3.4.22 Хамт олны дунд хов жив ярих зэргээр хамт олныг хагалан бутаргах үйл ажиллагаа явуулахгүй байх;
- 3.4.23 Байгууллагын эд хөрөнгө завших, хулгай хийх, байгууллагын эд хөрөнгөнд ариг гамгүй хандах зэрэг зөрчлийг гаргахгүй байх;
- 3.4.24 Өөрийн шууд удирдлагад ажиллаж буй ажилтан болон бусад хамтран ажиллагсдад сэтгэл зүйн болон бэлгийн дарамт үзүүлэхгүй байх;


 НОМИН	"НОМИН ЮНИТИ" ББСБ	Дугаар: ДМ/4-6/01	Иш татсан заалт: Ёс зүйн дүрэм
ЁС ЗҮЙН ДҮРЭМ		Хувилбар: 2	

ДӨРӨВ. ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

- 4.1 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүний ёс зүйн хэм хэмжээ**
- 4.1.1 Харилцагч, хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хангаж ажиллах;
- 4.1.2 ББСБ-ын үйл ажиллагаанд заавал дагаж мөрдөхөөр заасан хууль тогтоомж, зохицуулалтыг чанд баримтлан, байгууллагын дүрэм болон хувьцаа эзэмшигчийн шийдвэрийн дагуу тогтоосон эрх мэдлийн хүрээнд эрх үүргээ хэрэгжүүлэхдээ энэхүү дүрэмд тусгасан ёс зүйн зарчимд нийцүүлэх;
- 4.1.3 Байгууллагын өмнө хүлээсэн үүргээ хувийн ашиг сонирхлоос ангид үзэж, сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх бөгөөд эрх мэдлээ ашиглан хувьдаа ашиг олох, ямар нэг давуу байдал үүсгэхгүй байх;
- 4.1.4 Байгууллагын нэр хүнд, үйл ажиллагаанд хамаарах асуудлаар байр сууриа зөв бөгөөд ойлгомжтой тодорхой илэрхийлэх, ББСБ-н үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх мэдээллийн эсрэг хамгаалах, олон нийтийн дунд итгэл, хүндлэлийн ёс зүйн өндөр жишгийг баримтлал болгон ажиллах;
- 4.1.5 Эрх үүргээ хэрэгжүүлэхдээ мэдлэг ур чадвараа дайчлан, хичээл зүтгэл гарган ажиллах бөгөөд шийдвэр гаргахдаа үндэслэлтэй, үнэнч шударга хандаж, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах;
- 4.1.6 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалд аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэж, тухайн асуудлыг шийдвэрлэхэд санал хураалтад оролцохгүй байх;
- 4.1.7 Энэхүү дүрмийг зөрчсөн үйлдэл, эс үйлдлээс татгалзах, шаардлагатай тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд гишүүний эрх үүргээс татгалзах санал гаргах;
- 4.1.8 Байгууллагын үйл ажиллагаа хууль тогтоомж, дүрэм, журамд нийцтэй эсэхийг шалгаж сайжруулахад хувь нэмрээ оруулах;
- 4.1.9 Хэрэв байгууллагын ашиг сонирхол, тогтвортой үйл ажиллагаанд зөрчил үүссэн эсвэл үүсгэж болох нөхцөл байдлыг олж мэдсэн бол зөрчлийг арилгах арга зам, чиглэл, үүрэг даалгаврыг мэргэжлийн өндөр түвшинд, баримт нотолгоо дээр үндэслэж өгөх;
- 4.1.10 Төлөөлөн удирдах зөвлөл нь байгууллагын ёс зүйн хорооны үүргийг гүйцэтгэж энэхүү дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллах ба дүрэмд заасан хэм хэмжээг аль нэг ажилтан/ажилтнууд зөрчсөнийг мэдсэн тохиолдолд холбогдох арга хэмжээг авах;
- 4.2 Удирдлагын багийн гишүүдийн ёс зүйн хэм хэмжээ**
- 4.2.1 ББСБ-н үйл ажиллагаанд заавал дагаж мөрдөхөөр заасан хууль тогтоомж, эрх зүйн актыг баримтлан, байгууллагын дүрэм, журам, хөдөлмөрийн гэрээнд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллах, эрх мэдлээ хэрэгжүүлэн, чиг үүргээ чандлан биелүүлэх;
- 4.2.2 Байгууллагын ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж, өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ энэхүү дүрмийн 4-р бүлэгт заасны дагуу ашиг сонирхлын зөрчил, авилга, хээл хахуулиас ангид хуулийн хүрээнд ажиллах;

 НОМИН	"НОМИН ЮНИТИ" ББСБ	Дугаар: ДМ/4-6/01	Иш татсан заалт: Ёс зүйн дүрэм
ЁС ЗҮЙН ДҮРЭМ		Хувилбар: 2	


- 4.2.3 Байгууллагын стратеги, бодлого, төлөвлөгөө боловсруулах, асуудал шийдвэрлэх, албан үүргээ хэрэгжүүлэхдээ мэдлэг ур чадвараа дайчлан, хичээл зүтгэл гарган ажиллах бөгөөд хуульд нийцсэн, бодит баримт нотолгоо, тооцоололд тулгуурласан, үндэслэл бүхий шийдвэрийг гаргах;
- 4.2.4 Байгууллагын зорилго, зорилт чиг үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах;
- 4.2.5 Удирдах, удирдуулах ёсны зарчмыг баримталж ТУЗ болон Гүйцэтгэх захирлаас гаргасан /Гүйцэтгэх захирлын хувьд ТУЗ, Хувьцаа эзэмшигчдийн хурал-аас гаргасан/ хуульд нийцсэн шийдвэр, чиглүүлэг, өгсөн үүрэг даалгаврыг хүндэтгэн үзэж, цаг тухайд нь биелүүлэн ажиллах;
- 4.2.6 Өөрийн гаргасан шийдвэрийнхээ талаар ажилтны саналыг сонсож, харилцан уялдаатай эргэх холбоотой ажиллах;
- 4.2.7 Байгууллагын нэрийн өмнөөс бусад байгууллага, иргэдтэй хамтран ажиллахдаа ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- 4.2.8 Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрсөн ажил үүрэг эрхэлдэг эсвэл эрхлэх гэж байгаа бол удирдлагад заавал мэдэгдэх;
- 4.2.9 Бусад албан тушаалтны үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, саад болох, хууль бус үйлдэл хийхийг шаардах, үүрэг даалгавар өгөхийг хориглоно;
- 4.2.10 Өөрийн шууд удирдлагад хамаарал бүхий этгээд болон нэгдмэл сонирхолтой этгээдийг ажиллуулахаас татгалзах, удирдлагад мэдэгдэх;
- 4.2.11 Албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;
- 4.2.12 Өөрийн буруутай үйл ажиллагаанаас алдаа гарсан тохиолдолд гэм буруугаа шударгаар хүлээж дахин давтахгүй байх;
- 4.2.13 Хууль зөрчсөн, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэлтэй үл эвлэрч, зөрчил дутагдлыг өмөөрөн хаацайлахгүй бөгөөд өөрийн болон бусдын алдаа дутагдлыг илрүүлэн засаж ажиллах;
- 4.2.14 Хэрэв байгууллагын ашиг сонирхол, тогтвортой үйл ажиллагаанд зөрчил үүссэн эсвэл үүсгэж болох нөхцөл байдлыг олж мэдсэн бол зөрчлийг арилгах арга зам, чиглэл, үүрэг даалгаврыг мэргэжлийн өндөр түвшинд, баримт нотолгоон дээр үндэслэж өгөх;
- 4.3 Ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээ**
- 4.3.1 Хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөж байгаа дэг журам, дүрэм зааврыг чанд баримталж, байгууллагын эрхэм зорилго, зорилт, үнэт зүйлийг ямагт дээдлэх;
- 4.3.2 Өөрийн мэдлэг чадвар, туршлагаа байнга хөгжүүлж, үүрэгт ажлаа мэргэжлийн өндөр түвшинд үнэнч шударгаар хариуцлагатай гүйцэтгэж, ажилдаа хүндэтгэлтэй хандах;
- 4.3.3 Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу ажлын цагийг бүрэн, үр бүтээлтэй ашиглах;
- 4.3.4 Удирдах, удирдуулах зарчмыг баримталж, удирдлагаас гаргасан шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг хүндэтгэн, цаг хугацаанд нь биелүүлэх;

 НОМИН	"НОМИН ЮНИТИ" ББСБ	Дугаар: ДМ/4-6/01	Иш татсан заалт: Ёс зүйн дүрэм
ЁС ЗҮЙН ДҮРЭМ		Хувилбар: 2	

- 4.3.5 Удирдах ажилтныг асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад нь хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээллээр хангах;
- 4.3.6 Аливаа хууль бус үйлдэл, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай удирдлагад мэдээллэх;


ТАВ. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ, АВИЛГА, ХЭЭЛ ХАХУУЛИАС АНГИД ХУУЛИЙН ХҮРЭЭНД АЖИЛЛАХ

- 5.1 Бүх ажилтан, албан тушаалтнууд байгууллагын ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж, хууль дүрэм журмыг чандлан мөрдөж, өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж дараах этгээдүүдэд шууд болон шууд бусаар ашиг хонжоо олгоход чиглэсэн үйлдэл, эс үйлдлийг гаргахыг хориглоно. Үүнд:
- 5.1.1 Өөртөө;
- 5.1.2 Өөрт хамаарал бүхий этгээд;
- 5.1.3 Өөрийн нэгдмэл сонирхолтой этгээд;
- 5.2 Албан үүргээ гүйцэтгэсэн болон гүйцэтгээгүйн улмаас ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод, гадаадын аливаа иргэн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирох, амлалт өгөх, тэднээс хээл хахууль, бэлэг, урамшуулал, шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, хууль бус бусад хангамж эдлэхээс татгалзана.
- 5.3 Ажилтан байгууллага дахь өөрийн ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх буюу нөлөөлж болзошгүй, мөн ашиг сонирхлын зөрчил үүсгэх буюу үүсгэж болзошгүй ажлыг байгууллагаас гадуур давхар эрхлэх, оролцохыг хориглоно.
- 5.4 Бизнесийн харилцаагаа өргөжүүлэх зорилгоор, мөн баяр ёслол тэмдэглэлт ойн өдрүүдэд мөнгөн хэлбэрийн бус бэлэг дурсгал өгөх эсвэл хүлээн авах тохиолдол байж болох бөгөөд бэлэг дурсгал хүлээн авах, өгөх үйл ажиллагаа нь зөвхөн байгууллагын ашиг сонирхлын төлөө байна.
- 5.5 Баяр ёслол болон бусад үед харилцагч нарт гарын бэлэг өгөхдөө зөвшөөрөгдсөн зардал, төсвийн дагуу бэлтгэж өгөх ба бэлэг авах үед бэлэг дурсгалын зүйл нь дараах байдалтай байвал зохино. Үүнд:
- 5.5.1 Байгууллагын ашиг сонирхолд нийцсэн;
- 5.5.2 Мөнгөн хэлбэрийн бус;
- 5.5.3 Үүрэг, хариуцлага, хүлээлт найдлага шаардаагүй;
- 5.5.4 Хийгдэж буй яриа хэлцлийн үр дүнд нөлөө үзүүлэх зорилгогүй;
- 5.5.5 Байгууллагад нээлттэй, ердийн байдлаар хаяглагдсан;
- 5.6 Гүйцэтгэх захирлын зөвшөөрөлгүйгээр байгууллагын нэрийн өмнөөс аль нэг улс төрийн хүчинд хандив өгөх,, байгууллагын хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг улс төрийн аливаа үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.;
- 5.7 Ажил үүрэг гүйцэтгэхтэй холбоотойгоор бусад ажилтан болон гуравдагч талаас хахууль авах зорилгоор тэдэнд хууль бус үйлдэл хийх дарамт шахалт үзүүлэхгүй байна.

 НОМИН	"НОМИН ЮНИТИ" ББСБ	Дугаар: ДМ/4-6/01	Иш татсан заалт: Ёс зүйн дүрэм
ЁС ЗҮЙН ДҮРЭМ		Хувилбар: 2	

ЗУРГАА. ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙГ МЭДЭЭЛЭХ, ШИЙДВЭРЛЭХ

- 6.1 Ажилтан хууль тогтоомж болон энэхүү дүрэмд заасан хэм хэмжээг зөрчсөн, зөрчигдөж байгааг мэдсэн тохиолдолд энэ тухай ББСБ-н төлөөлөн удирдах зөвлөлд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
- 6.2 Төлөөлөн удирдах зөвлөл нь зөрчлийн талаарх мэдээллийг тухай бүр хүлээн авч, шийдвэрлэх, мэдээлэгчийн нууцлалыг хадгалах үүрэгтэй.
- 6.3 Харилцагч болон олон нийтээс ББСБ-н ажилтан, үйл ажиллагаатай холбоотой ёс зүйн зөрчлийн талаар төлөөлөн удирдах зөвлөлд мэдээлж болно.
- 6.4 Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл, өргөдөл, гомдлоо, бичгээр хүргүүлэх бөгөөд нотлох баримтыг хавсаргана. Мөн нэрээ нууцлах зорилгоор нэргүй мэдээллийг байгууллагын салбар дээр байршуулсан санал гомдлын хайрцагт хийж болно.
- 6.5 Ажилтны гаргасан зөрчлийг мэдсээр байж нуун дарагдуулсан албан тушаалтанд дүрэмд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 6.6 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хүлээн авсан өргөдөл гомдлыг эхний ээлжид холбогдох алба, хэлтсийн удирдлагад хуваарилна. Харин удирдлагын багийн гишүүдтэй холбоотой өргөдөл гомдлыг шууд төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.
- 6.7 Гүйцэтгэх захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнтэй холбоотой ёс зүйн зөрчлийн талаарх өргөдөл гомдлыг ёс зүйн хорооны хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.
- 6.8 Хэрэв гомдол хүлээн авсан газар, хэлтсийн удирдлага тухайн гомдлыг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.
- 6.9 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн тухайн өргөдөл, гомдлыг хүлээн авч, зөрчлийн мэдээллийн тэмдэглэлд бүртгэх ба шийдвэрлэсэн байдлыг нь давхар бүртгэнэ.
- 6.10 Ёс зүйн зөрчлийн талаарх өргөдөл гомдлыг хүлээн авсан газар, хэлтсийн удирдлага ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэнэ, гомдол гаргагч болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд бичгээр эсвэл и-мэйлээр мэдээлэх үүрэгтэй.
- 6.11 Зөрчил гаргасан ажилтныг төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд тухайн алба, хэлтэс хариуцсан удирдах ажилтан нь биечлэн оролцуулах үүрэг хүлээнэ;
- 6.12 Төлөөлөн удирдах зөвлөл нь зөрчлийн мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор хурлаар хэлэлцэн, шалгаж, шийдвэрлэж, тодорхой үндэслэл бүхий дүгнэлт гаргана.
- 6.13 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд хэлэлцэж байгаа ажилтанд ногдуулах хариуцлагын талаар саналаа нууцаар гаргана.
- 6.14 Дүрмийн зөрчлөө ажилтан хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ахлуулсан шинжээчийн баг уг асуудлыг шалгаж, дүгнэлт гарган төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дахин хэлэлцүүлнэ.
- 6.15 Зөрчил гаргасан нь хяналтын зөвлөлийн хурлаар тогтоогдсон тохиолдолд Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, компанийн холбогдох дүрэм, журамд заасны дагуу зохих арга хэмжээ авна.
- 6.16 Ёс зүйн зөрчил гаргасаны улмаас харилцагч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, удирдлагын багийн гишүүн, ажилтан ББСБ-н эд хөрөнгөнд хохирол учруулсан тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулсан эсэхээс үл хамааран Монгол Улсын

 НОМИН	"НОМИН ЮНИТИ" ББСБ	Дугаар: ДМ/4-6/01	Иш татсан заалт: Ёс зүйн дүрэм
ЁС ЗҮЙН ДҮРЭМ		Хувилбар: 2	

Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмын дагуу эд хөрөнгийн хариуцлага хүлээнэ.

- 6.17 Хэрэв харилцагч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, удирдлагын багийн гишүүн, ажилтны гаргасан зөрчил нь Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийн шинжтэй бол холбогдох хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

-----oOo-----